



35

**БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 10 сарын 10

№ 895

Улаанбаатар  
хот

**Машин-Механизмын "Мон-Маш"  
компани байгуулах тухай**

Мэргэжлийн ажлын онцлог болон нийт хөрөнгийн хэмжээг харгалзан БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Барилгын 2 дугаар компанийн авто-машин механизмын баазыг барилгын машин механизм үйлчилгээний "Мон-Маш" компани /Улсын үйлдвэрийн газар/ болгон өөрчилж, 1991 оны 10 дугаар сарын 10-наас аж ахуйн бие даасан тооцоон дээр ажиллуулсугай.

2. "Мон-Маш" компанийг Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны шууд харьяанд ажиллуулан, дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. "Мон-Маш" компанийн жилийн цалингийн санг баталж өгөхийг санхүүгийн газар /н.Тонгор/-т даалгасугай.



**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА**

**ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Л.ЭНЭБИШ**

**Ц.БОЛДСАЙХАН**



Улаанбаатар хотын Ардын Хурлын  
Гүйцэтгэх захиргааны 1991 оны  
Засаг дарга 295-дугаар тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ЗАМ БАРИЛТЫН МАШИН МЕХАНИЗМЫН  
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ "МОН-МАШ" КОМПАНИЙН  
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Мон-маш" компани нь Богд хан багшинд хөрөнгийн харилцах данс бүхий аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр ажиллан тусдаа тайлан тэнцэл гаргаж улсын нэгдсэн дүн бүртгэлд оруулдаг, БИМАУ-д нийтэд цагаж мөрдөгдөн байгаа хууль тогтоомж, энэ дүрэмд зохицуулан үйл ажиллагаагаа явуулдаг Улаанбаатар хотын Ажилчны дүүрэг дэх улсын үйлдвэрийн газар мөн.

1.2. Компанийн үндсэн зорилт нь нийслэл хотын иргэний ба соёл үйлчилгээний барилга байгууламж барих, бусад үйлдвэр үйлчилгээний хүрээнд машин механизмаар үйлчлэхэд өмчийн хамгийн зохистой хэлбэрт тулгуурлан зах зээлд шилжих дэвшилттэй технологи, эдийн засгийн үйл ажиллагаа нэвтрүүлэх замаар ажиллагсдын амьдралын нөхцлийг баталгаажуулахад оршино.

1.3. Компани нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өнрөөс эхлэн бие даасан хуулийн этгээцийн эрх эдлэнэ.

Хоёр. Зохион байгуулалт, бүтэц

2.1. "Мон-маш" компани нь захиргаа, машин механизмын үйлчилгээний хэсэг, засварын цехүүдээс бүрдэнэ.

2.2. Компанийн дээд эрхийг жилд нэгээс цөөнгүй хуралдах нийт ажиллагсдын хурал бөгөөд түүний чөлөө цагт өдөр тутмын шуурхай удирдлагыг ерөнхий захирал шууд гүйцэтгэнэ.

2.3. Компанийн ерөнхий захирлыг хамт олны саналыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргын захирамжаар, ерөнхий ня-бо, дэд захирал, хэсгийн дарга нарыг захирлын тушаалаар тус тус томшино.

2.4. Компанийн ерөнхий захирал нэг сараас дээш хугацаагаар ажил үүрэг хүндэтгэх шалтгаанаар гүйцэтгэх боломжоогүй үед /сонгууль, томилолт, өвчлөлт/ ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч томшион энэ дүрмээр тогтоосон эрх үүргийг эдлүүлнэ.



2.

2.5.Компани нь I гишүүнтэй УУГ-ын хувьд өөрийн өцөр тутмын үйл ажиллагааг явуулахдаа хамт олны хурал уулзалтаас гарсан саналыг үндэслэн зохион байгуулна.

2.6.Компани нь тогтоогдсон журмаар хийгдсэн өөрийн нэр бүхий тэмцэгтэй байх бөгөөд албан бичиг хэрэгтээ таних тэмдэг, нэр хаягтай хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Турав.Компанийн үүрэг

3.1.Компанийн захиргаа нь барилгын болон үйлдвэр үйлчилгээний байгууллага, хувь хүмүүстэй аж ахуйн гэрээ, тохиролцооны журмаар газар шорооны механизм, өргөх тээвэрлэх хэрэгслээр үйлчлэхэд зах зээлийн эдийн засгийн шаардлага хангах үр ашигтай шинэ техник технологи нэвтрүүлэх замаар ашигтай ажиллахад удирдлага зохион байгуулалтыг чиглүүлнэ.

3.2.Удирдах болон мэргэжлийн боловсон хүчнээр хангах, тэдний ачаалал, ажил үүргийг тэнцвэртэй зохистой зохицуулна.

3.3.Ажиллагсдын цалин хөлс, амралт, тэтгэвэр тэтгэлгээ, орон сууц, соёл ахуй, нийгмийн асуудлыг онцгойлон анхаарна.

3.4.Хамт олны дунд өмчийн шинэ хэлбэрүүд, зах зээлийн эдийн засгийн онцлог чанар, улс орны байдал, иргэний эрх үүрэг, хөдөлмөрийн сахилга, дэг журмын талаар тодорхой мэдлэг олгох, хэрэгжүүлэх замаар эвсэг хамт олныг бүрэлдүүлэн тогтооно.

3.5.Ажиллагсдаас хөдөлмөрийн эрхийн харьцааны талаар гарсан санал хүсэлт, гомцлын асуудлыг хууль зүйн хүрээнд шуурхай шийдвэрлэнэ.

3.6.Үйлдвэр, үйлчилгээ санхүүгийн сар, улирал, жилийн үйл ажиллагааны тайлан тэнцэлийг тогтоосон хугацаанд гарган, хамт олноор хэлэлцүүлэн, шаардагдах оновчтой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.7.Тэргүүний хамт олон, хувь хүн, онцгой бүтээлч хүмүүсийг шалгаруулан хөхүүлэн шагнах, засаг төрийн шагналд уламжлан шийдвэрлүүлнэ.

Дөрөв.Захиргааны эрх

Захиргаа нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үүргийг биелүүлэхэд дараах үндсэн эрхийг эдлэнэ. Үүнд:



## 3.

4.1.Захиргаа үйлдвэр үйлчилгээний ажил явуулахдаа гадаад дотоодын аль ч байгууллагатай ажил төрлийн харьцаа тогтоож, гэрээ хэлэлцээрийг бие даан явуулж, бичиг баримт батлах, цуцлах, өөрчлөлт оруулах, хариуцагчаар оролцоно.

4.2.БНМАУ-ын хөдөлмөрийн хууль бусад хууль тогтоомжийн дагуу ажилчин албан хаагчийг ажилд авах, халах, шагнаж урамшуулах, сахилгын хариуцлага ноогдуулна.

4.3.Ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх, ахуй хангамж, соёлын арга хэмжээ, шагнал олгох, хөнгөлөлт туслалцаа үзүүлэхэд хөрөнгө гаргана.

4.4.Машин механизм, сэлбэг материал, багаж хэрэгслэлийг бусдад шилжүүлэх, худалдан авах, борлуулах журмаар технологийн шинэчлэлт хийнэ.

4.5.Цех, үйлдвэрийн нэгжийг хоршоо, компани, хувь хүнд түрээсээр эзэмшүүлэх, хувьчлах, хорших болон хамтарсан үйлдвэр байгуулах талаар тооцоо дүгнэлт гаргаж хэрэгжүүлнэ.

4.6.Бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг үндэслэн өөрийн дотоод журмаар ажиллагсдын эрх үүргээ боловсруулан хамт олноороо хэлэлцэж батлах, нэмэлт өөрчлөлт оруулна.

4.7.Компани нь өөрийн үйл ажиллагаа үр ашгаа дээшлүүлэхээр бусад төрлийн үйлчилгээ нээх, гадаад дотоодод салбар гаргах ажил зохионо.

4.8.Компанийн эрх ашгийг хохироосон буюу өөр замаар хөндсөн тохиолдолд шүүх хуулийн байгууллагаар эрхээ хамгаалуулах, нэхэмжлэл гаргах, хариуцагчаар оролцоно.

#### Тав.Компанийн эд хөрөнгө

5.1.Компани нь аж ахуйн бүрэн тооцоон дээр ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлнэ.

5.2.Компанийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хэмжээгээр эхлэлийн тайлан тэнцэлд дүрмийн санг 18 сая төгрөгөөр тогтооно.

5.3.Эргэлтийн хөрөнгийг удирдах дээд байгууллагатай тохиролцон өөрөө тооцно.

Зургаа.Компанийн орлого

6.1.Компани нь машин механизмаар ажил үүрэг гүйцэтгэсэн болон үйлдвэр үйлчилгээний байгууллагуудад техникт засвар хийсэн ажлын хөлс.

6.2.Хуучин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд зангилгаа болон илүүдэлтэй сэлбэг материал борлуулсан орлого

6.3.Үйлдвэрийг хөгжүүлэх шинэтгэлтэй холбогдтуулан улсаас авсан төрөл бүрийн зээлийн сан хөмрөг

6.4.Бусад орлого

Долоо.Компанийг татан буулгах эцсийн тооцоо хийх

7.1.Компани нь БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлээ үйл ажиллагаагаа зогсооно.

7.2.Компанийн эцсийн тооцоог хууль тогтоомжид заасан журмаар тусгай комисс томилон тооллого үнэмтээ хийж нийтэд зарлан мэдээлж татан буулгана.